

67



ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Дотоод хяналтын камер ажиллуулах журам

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйл, Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 5 дугаар зүйлийн 5.2 мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1 дэх заалт, мөн журмын 5.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн ажлын байранд хувь хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор эмнэлгийн хэмжээнд "Хяналтын камер ажиллуулах журам"-ыг нэгдүгээр, камерын үйл ажиллагаатай холбоотой хөтлөх маягтуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан дэд захирал (Б.Батзориг), Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан дэд захирал (Р.Гантуяа), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба (Б.Бат-Оргил) нарт үүрэг болгосугай.

3. Эмнэлгийн хэмжээний камер хяналтын системийн нууцлал аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах ажлыг холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллах, хяналтын камерын байрлах цэгүүдийг батлуулахыг Мэдээлэл технологийн алба (Э.Батдорж)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд шаардлагатай төсвийг батлагдсан төсвийн хүрээнд гаргахыг Санхүү бүртгэлийн алба (Ц.Энхбаярт)-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

ХЯНАЛТЫН КАМЕР АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Эмнэлэгийн үйл ажиллагаанд хувь хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Эмнэлгийн орчинд зохион байгуулагдаж буй дараах үйл ажиллагааг хяналтын камер /цаашид камер гэх/-ыг ашиглаж хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.
Үүнд:
 - 1.2.1. Эмнэлгийн нийтийн эзэмшил, ажлын байранд эмнэлэгийн ажилчдын аюулгүй байдлын хангах;
 - 1.2.2. Системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгын хүрээнд аливаа санаатай болон санамсаргүй үйлдсэн гэмт хэрэг, халдлага, хорлон сүйтгэх болон хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шаардлагатай арга хэмжээ авахтай холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулах;
 - 1.2.3. Эмнэлгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах;

ХОЁР. ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨРӨЛ

- 2.1. Камер нь энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасан нэр төрөл техникийн үзүүлэлтийг хангасан байна.
- 2.2. Хяналтын төхөөрөмж нь журамд заасан нэр төрлөөр хязгаарлагдахгүй ба журмын үндсэн зорилгыг хангах зорилтын хүрээнд техникийн дэвшилтэт бусад арга хэрэгслийг ашигласан бүх төрлийн төхөөрөмж байж болох бөгөөд ашиглалтын стандартад нийцсэн байна.
- 2.3. Эмнэлэг нь зориулалтаас хамааран дараах камеруудыг ашиглаж болно. Үүнд:
 - 2.3.1. Гадна хяналтын камер: Хяналтын орчны дүрсийг харах зориулалттай, байгууламж болон тусгайлан зориулсан шон дээр суурьлуулсан чиглэлийн камер
 - 2.3.2. Дотор хяналтын камер: Дотоод орчныг хянах зорилгоор ашиглах камер
 - 2.3.3. Хөдөлгөөнт камер: Хөндлөн болон хэвтээ чиглэлд хөдөлж, дурангийн тусламжтайгаар дүрсийг татаж, томруулах зориулалт бүхий камер
 - 2.3.4. Тусгай зориулалтын камер: тээврийн хэрэгслийн улсын дугаар таних, бүртгэх, бүртгэх, дулаан мэдрэгч, зэвэрдэггүй, ус чийгний хамгаалалттай камер

ГУРАВ. КАМЕР ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 3.1. Эмнэлгийн хэмжээний камер хяналтын төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээг Мэдээлэл технологийн алба /МТА/ хариуцна.
- 3.2. Хяналтын төхөөрөмжүүдэд жилд 2-оос доошгүй удаа техникийн үзлэг, үйлчилгээ хийх ба цэвэрлэгээг шаардлагатай тохиолдол бүрт хийнэ.
- 3.3. Хяналтын камер хариуцсан инженер нь сар бүрийн эхний долоо хоногт хяналтын камер болон бичигч төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалган тэмдэглэл хөтөлнө.
- 3.4. Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд гэмтлийн шалтгааныг яаралтай хугацаанд тодорхойлон боломжит гэмтлийг 24 цагийн дотор засварлана. Шинээр сэлбэг

- хэрэгсэл авах эсвэл бүтнээр нь шинэчлэх шаардлагатай бол яаралтай журмаар шийдвэрлүүлнэ.
- 3.5. Камер хяналтын төхөөрөмжийг шинэчлэх болон урсгал засварын зардлыг жил бүрийн төсөвт тусган оруулж шийдвэрлүүлнэ.
- 3.6. Эвдрэлийн түвшнээс хамааран засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.
- 3.7. МТА нь камер хяналтын төхөөрөмжийн 24 цагийн тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор техникийн тодорхойлолт, зааварчилгааг холбогдох нийлүүлэгчээс авсан байх бөгөөд шаардлагатай засвар үйлчилгээ, програм хангамжийн хөгжүүлэлтийг баталгаат хугацаанд нь нийлүүлэгч байгууллагаар гүйцэтгүүлэх ба баталгаат хугацаа дууссан тохиолдолд МТА-ны сүлжээний инженер гүйцэтгэн ажиллана.

ДӨРӨВ. ТЕХНИК ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬЛУУЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

4. Хяналтын камерын систем, хяналт, видео аналитикийн шийдэл нь дараах шаардлагыг хангасан байна.
- 4.1.1. Хяналтын камерын үзүүлэлт:
- 4.1.1.1. Камер нь тоон технологи дээр суурилсан IP камер байна;
- 4.1.1.2. Дүрсний нягтаршил: Дотор орчинд 2 мигапиксел /1980x1080 25 frame/sec/-ээс багагүй, гадна орчинд 4 мигапиксел /2560x1600 frame/sec/-ээс багагүй;
- 4.1.1.3. Дүрс хувиргаж дамжуулах шахалтын горим нь H.265+ болон түүнээс дээш;
- 4.1.1.4. Сүлжээний орчинд хандах хандалтын (IPV4/V6, HTTP, HTTPS, FTP SFTP, RTSP, uPnP, P2P) протоколуудыг дэмжиж ажилладаг;
- 4.1.1.5. Хэрэглэгчийн нууц үг, сүлжээний (IP) хаягийн хязгаарлалт, HTTPS кодлолын хамгаалалттай;
- 4.1.1.6. Тоон буюу IP камер нь ONVIF, NEMA 4X, IK10 стандартыг хангасан байхаас гадна суурилуулах камер нь нэмэлтээр IP66 стандарт шаардлагыг хангасан;
- 4.1.1.7. Гадна орчинд ажиллах камер нь Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон -40° хэмээс + 50° хэмд ажиллах шаардлагыг хангасан, ус чийг, тоосжилтоос хамгаалагдсан гадна зориулалтын камер байна.
- 4.1.1.8. Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах, өдөр шөнийн автомат тохируулга, үйл ажиллагаатай байна.
- 4.1.1.9. Орчны гэрэлтүүлгийн байдлаас хамаарч гэрлийн 0,0001-3,4 люкс (харанхуй) нэгжид хяналтын орчинг харах чадамж бүхий өөртөө болон нэмэлт гэрэлтүүлэгтэй байж болно.
- 4.1.1.10. Дүрсний хоцрогдолгүй 1-ээс илүүгүй секундэд боловсруулдаг байх.
- 4.1.1.11. Тоон буюу IP телекамерын тэжээлийг Power over Ethernet /PoE/ технологиор шийдэх тохиолдолд дотор телекамер нь IEEE 802.3af, гадна телекамер нь IEEE 802.3at тэжээлийн стандартыг дэмждэг байна.
- 4.1.1.12. Хөдөлгөөнт камер нь хэвтээ тэнхлэгт тулахгүй 360°, босоо тэнхлэгт 180°-аас багагүй, дурангийн оптик таталт 36 дахин, тоон таталт 10 дахин, линз /4.7-94/, гэрэлтүүлэг /өнгөт 0.05 lux-д 30 IRE F1.6, хар цагаанд 0.01 lux-д 30 IRE F1.6/, өөрөөс гаргах IR гэрэлтүүлэгтэй хамгийн багадаа 150м түүнээс дээш байна.
- 4.1.2. Бичлэг хадгалах төхөөрөмж гэж камераас дүрсийг хүлээн авч боловсруулах, хадгалах, ашиглах нөхцөл бүрдүүлж буй програм, техник хангамж бүхий төхөөрөмжийг хэлэх бөгөөд дараах шаардлагуудыг хангасан байна.
- 4.1.2.1. Дүрс бичлэгийн төхөөрөмж нь бүх сувагтаа 3072x2048 25 фрейм/секундээс дээш чанартай дүрс бичлэг хийдэг байна.